



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 25/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн дүнгээс 73.2 хувиар тооцож нийт 99,586,363.00 (ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 1.00 (нэг) төгрөгийн ногдол ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/-д үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 04 дугаар сарын 31-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан тараасугай.

5. Энэхүү ногдол ашиг хуваарилалтын шийдвэр болон ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Д.Балдорж/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ